

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

“Монголбазальт” ХХК-ийн нийтэд санал
болгон гаргах хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.8, 34.1.7, Хорооны 2006 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголбазальт” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 75 491 900 ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон гаргах үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 36 000 000 ширхэг хувьцааг нийтэд санал болгон арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д зөвшөөрсүгэй.

3. Анхдагч зах зээлийн арилжааг нээсэн өдрөөс эхлэн ажлын 10 хоногийн дотор энэ тогтоолын 2-т заасан 36 000 000 ширхэг хувьцаанаас 70 хувь буюу 25 200 000 ширхэг хувьцаа арилжигдаагүй тохиолдолд үнэт цаасаа нийтэд санал болгох ажиллагааг амжилтгүй болсонд тооцох болно гэдгийг “Монголбазальт” ХХК /Л.Ариунболд/, Андеррайтерийн “Ворлдкей” ХХК /Н.Мянганбаяр/, “Батс инвест” ХХК /Л.Жавзмаа/-д тус тус анхааруулсугай.

4. Энэ тогтоолын 3-т заасны дагуу 70 хувь буюу 25 200 000 ширхэг хувьцаа арилжигдсаны дараа үлдсэн 30 хувь буюу 10 800 000 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг хуанлийн 60 хоногийн дотор явуулж дуусгахыг “Монголбазальт” ХХК /Л.Ариунболд/, Андеррайтерийн “Ворлдкей” ХХК /Н.Мянганбаяр/, “Батс инвест” ХХК /Л.Жавзмаа/-нд тус тус үүрэг болгосугай.

5. Анхдагч зах зээлийн арилжааны явцад үнэт цаас гаргагчийн нэр дээр тусгайлан данс нээх, уг дансанд хувьцааны арилжааны төлбөр болох мөнгөн хөрөнгийг байршуулж ажиллахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын 5-д заасан мөнгөн хөрөнгийг Хорооноос үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагааг амжилттай болсонд тооцох хүртэл улсын байцаагчийн албан шаардлагаар тусгаарлахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

7. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа “Монголбазальт” ХХК-ийн 2008 оны хувь нийлүүлэгчдийн хурлын 001 тоот тогтоолыг үндэслэн 100 төгрөгийн

нэрлэсэн үнэ бүхий 39 491 900 (гучин есөн сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга есөн зуун) ширхэг хувьцаанаас “Монголбазальт” ХХК-ийг үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч иргэн Л.Ариунболдын нэр дээр 20 140 869 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг, иргэн П.Сайнбилэгийн нэр дээр 7 503 461 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг, иргэн А.Энхгэрэлийн нэр дээр 3 949 190 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг, А.Энхмаагийн нэр дээр 3 949 190 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг, А.Энхжингийн нэр дээр 3 949 190 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг тус тус үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

8. Энэ тогтоолын 7-д заасан нэр бүхий үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн өмчлөлд бүртгэсэн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаа явагдах эхний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаагаар тусгаарлаж хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулахгүй байхыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

9. Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хувьцааны арилжаа, төлбөр тооцоо, бүртгэлийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

10. Энэ тогтоолын хавсралтаар баталсан нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны хураангуй болон дэлгэрэнгүй танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК болон өөрийн компанийн вэб хуудсанд байршуулах, зуучлагч “Брокер, дилерийн компани”-удад хураангуй танилцуулгыг хэвлэж хүргүүлэн нийтэд сурталчлах, танилцуулгыг нийтэд сурталчлахдаа хувьцааны үнэ, ханшны талаар аливаа амлалт өгөхгүй байх, олон нийтийг бодитой үнэн зөв мэдээллээр хангах, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн хуулиар олгогдсон эрхийг зохих журмын дагуу хангах, хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Монголбазальт” ХХК /Л.Ариунболд/, Андеррайтерийн “Ворлдкей” ХХК /Н.Мянганбаяр/, “Батс инвест” ХХК /Л.Жавзмаа/-д үүрэг болгосугай.

11. Нийтэд санал болгон гаргах үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа, үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан зохих баримт бичгүүдэд өөрчлөлт оруулан Үндэсний татварын ерөнхий газрын харьяа Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэн ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Монголбазальт” ХХК /Л.Ариунболд/-д үүрэг болгосугай.

12. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, олон нийтэд сурталчлан ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ